



АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
Санхүүгийн аудитын газар	Аудитын гэрчилгээ	3
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:	1. Аудит хийгдсэн Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	5
Ц.Наранчимэг	1.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
Аудитын менежер:	1.2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
Г.Гүнжидмаа	1.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Я.Самбууням	1.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
Ахлах аудитор:	2. Аудитын талаарх үндсэн мэдээлэл	10
Ц.Хосжаргал	3. Санхүүгийн тайлагналын хүрээ ба санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан аргачлал, зарчим	11
Л.Хонгорзул	4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	14
Д.Энхдалай	5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	15
Р.Цолмон	5.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15
Аудитор:	5.1.1. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	16
Б.Сэржмядаг	5.1.2. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	17
Ж.Болормаа	5.1.3. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	17
Б. Уянга	5.1.4. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	18
Г.Мөнхчимэг	5.1.5. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	18
Э.Энхбаатар	5.2. Богино хугацаат хөрөнгө оруулалт	19
Л.Мөнхцацрал	5.3. Авлага	19
Д.Болор-Эрдэнэ	5.3.1. Төрийн сангийн авлага	20
Б.Лхагвацэнд	5.3.2. Төсөвт байгууллагын авлага	21
Ц.Цэрэнхүү	5.3.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага	22
Б.Долгоржав	5.3.4. Нийгмийн даатгалын сангийн авлага	22
Д.Даваабаатар	5.4. Урьдчилгаа	23
2019 оны 6 дугаар сар	5.5. Урт хугацаат хөрөнгө оруулалт	23
Уг тайланг УАГ-ын	5.6. Бараа материал	24
Цахим хуудаснаас үзнэ үү:	5.7. Үндсэн хөрөнгө	25
www.audit.mn	5.7.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	25
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаарын утсаар харилцана уу.	5.7.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	26
ХАЯГ:	5.8. Өр төлбөр	27
Үндэсний аудитын газар	5.8.1. Төв төрийн сангийн өр төлбөр	28
Засгийн газрын IV байр,	5.8.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн зээлийн өглөг	29
Бага тойруу-6, Улаанбаатар-46	5.8.3. Төсөвт байгууллагын өр төлбөр	29
Монгол Улс	5.8.4. Төсөл, сангийн өр төлбөр	30
	5.8.5. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр	30
	5.8.6. Нийгмийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр	30
	5.9. Засгийн газрын хувь оролцоо	31
	5.9.1. Төрийн өмчийн хувь оролцоо	31
	5.9.2. Орон нутгийн өмчийн хувь оролцоо	32
	6. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	32
	6.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	32
	6.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	32
	6.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	32
	6.4. Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	33
	6.5. Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит	34
	7. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга	34
	8. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	35
	9. Дотоод аудит	35
	10. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	35
	11. Аудитын зөвлөмж	36
	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	37



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДОХ	Дархлал олдмолын хам
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУШС	Монгол Улсын шадар сайд
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУВС	Олон улсын валютын сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:92-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

2019.06.07 № 1125
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай дүгнэлт" өгөх үндэслэл болсон. Үүнд:

- Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, зээл ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй нийт 1,006.7 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Татан буугдсан Капитал банканд төсвийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 245.4 тэрбум, дамжуулан зээлийн авлагын 5.1 тэрбум нийт 250.5 тэрбум төгрөг оршин байхгүй, эргэн төлөгдөх эсэх нь эрсдэлтэй;
- Засгийн газрын тусгай сангийн холбогдох журмын шалгуур хангаагүй, төсөл арга хэмжээг санхүүжүүлж зээл олгосон, зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Оршин байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д. ЗАНДАНБАТ

АУДИТ ХИЙГДСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**1.1. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,709,808,535.5	14,687,883,432.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,320,577,827.7	4,625,684,273.4
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	352,931,221.4	579,231,218.0
АВЛАГА	4,257,508,989.5	4,598,498,623.2
УРЬДЧИЛГАА	492,408,478.0	465,011,695.3
БАРАА МАТЕРИАЛ	1,684,037,526.4	1,564,015,806.8
НӨӨЦИЙН БАРАА	146,615,656.8	156,671,348.6
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,455,728,835.7	2,698,770,467.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	31,812,192,202.9	42,082,950,404.8
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	6,006,198,489.1	6,930,007,102.2
Урт хугацаат хадгаламж	1,109,767,108.5	1,193,085,907.2
Үнэт цаас	181,029,321.6	411,098,740.9
Урт хугацаат зээл	4,715,402,059.0	5,325,822,454.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,805,993,713.8	35,152,943,302.6
Газар	2,254,380.8	33,357,051.2
Биет хөрөнгө	13,678,167,422.9	18,972,094,075.1
Биет бус хөрөнгө	11,581,531,019.4	15,342,471,100.0
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	544,040,890.7	805,021,076.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	45,522,000,738.4	56,770,833,837.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,068,248,097.6	29,798,446,538.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,400,376,010.5	3,016,665,830.0
Богино хугацаат үнэт цаас	1,407,116,000.9	77,254,830.0
Богино хугацаат зээлийн өглөг	1,500,985,459.0	1,362,191,567.3
Өглөг	1,043,667,229.8	1,181,540,599.8
Урьдчилж орсон орлого	448,607,320.8	395,678,833.1
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,667,872,087.1	26,781,780,708.8
Урт хугацаат үнэт цаас	10,878,146,261.2	12,350,655,731.7
Урт хугацаат зээл	12,789,725,825.9	14,431,124,977.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,453,752,640.7	26,972,387,298.4
Засгийн газрын хувь оролцоо	17,453,752,640.7	26,972,387,298.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,027,615,169.1	5,925,949,089.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,067,962,563.7	3,602,487,360.2
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	20,369,854.6	20,529,751.5
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,234,355,868.4	11,266,724,265.2
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	37,572,403.6	28,956,645.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,523,572,833.3	4,482,252,837.6
Хуримтлагдсан үр дүн	-5,342,622,677.0	-5,092,235,447.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,869,444,936.9	6,737,722,796.4
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	16,109,185.8	
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-627,497.7	
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	45,522,000,738.4	56,770,833,837.2

2. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	12,856,044,729.7	15,883,926,099.6
ТАТВАРЫН ОРЛОГО	7,048,846,835.9	8,848,810,175.5
Орлогын албан татвар	1,641,723,369.3	2,421,504,963.5
Хувь хүний орлогын албан татвар	695,355,048.8	855,953,325.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,474,216.7	-41,895,217.5
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчдийн орлогын албан татвар	446,029.4	307,011.6
ААН-ын орлогын албан татвар	990,396,507.8	1,346,172,224.1
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	260,967,619.4
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,439,650,402.9	1,699,082,364.2
Хөрөнгийн албан татвар	131,129,627.4	141,178,208.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,618,492,105.6	2,195,907,230.8
Онцгой албан татвар	519,721,527.5	754,440,177.8
Тусгай зориулалтын орлого	12,386,570.0	13,063,741.0
Гадаад үйл ажиллагааны орлого	512,351,193.0	682,218,223.6
Бусад татвар, төлбөр, хураамж	1,173,392,040.2	941,415,266.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,674,156,979.6	6,592,792,736.9
Нийтлэг татварын бус орлого	5,487,473,750.8	6,374,519,476.4
Хөрөнгийн орлого	29,112,378.7	16,071,153.4
Тусламжийн орлого	146,872,687.3	197,993,163.8
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	946,062.4	756,056.6
Зээлийн орлого	9,752,100.4	3,452,886.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	133,040,914.2	442,323,187.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,904,829,712.5	12,182,730,488.8
УРСГАЛ ЗАРДАЛ	10,430,123,538.8	11,542,348,286.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,904,527,907.5	6,773,187,193.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,053,127,522.7	2,148,967,594.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,406,898.7	218,019,608.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,286,831.4	269,861,021.2
Хангамж, бараа материалын зардал	486,077,491.8	522,237,487.7
Нормативт зардал	312,030,370.8	321,726,092.9
Эд хогшил, урсгал засварын зардал	62,186,299.0	68,507,732.1
Томилолт, зочны зардал	70,122,137.1	73,666,080.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,287,158,847.7	1,629,688,098.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,180,131,508.4	1,520,513,476.7
ХҮҮ	1,731,483,557.8	1,724,877,389.3
ТАТААС	201,531,610.8	242,712,135.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,592,580,462.7	2,801,571,569.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	474,706,173.7	640,382,201.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,951,215,017.2	3,701,195,610.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	368,440,097.0	303,358,950.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,259,714,681.8	3,288,409,036.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,059,940,432.4	716,145,524.4

3. АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,316,303,897.5	0.0	6,316,303,897.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,438,202,030.8	0.0	-1,438,202,030.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,878,101,866.7	0.0	4,878,101,866.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-24,595,626.3	0.0	-24,595,626.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	251,286,215.9	0.0	251,286,215.9
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	87,645,074.5	0.0	87,645,074.5
Өмчид гарсан өөрчлөлт	11,202,135,202.4	0.0	11,202,135,202.4
Зарласан ногдол ашиг	-760,524.8	0.0	-760,524.8
Тайлант үеийн үр дүн	1,059,940,432.4	0.0	1,059,940,432.4
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,453,752,640.7	0.0	17,453,752,640.7
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,453,752,640.7	0.0	17,453,752,640.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-347,553,456.6	0.0	-347,553,456.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,106,199,184.2	0.0	17,106,199,184.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	5,131,363,439.4	0.0	5,131,363,439.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,809,316,790.6	0.0	2,809,316,790.6
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-82,135,160.2	0.0	-82,135,160.2
Өмчид гарсан өөрчлөлт	1,298,848,141.6	0.0	1,298,848,141.6
Зарласан ногдол ашиг	-7,570,484.9	0.0	-7,570,484.9
Тайлант үеийн үр дүн	716,145,524.4	0.0	716,145,524.4
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,972,387,298.4	0.0	26,972,387,298.4

4. АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	21,188,216,511.9	20,621,949,782.4
ТАТВАРЫН ОРЛОГО	7,109,941,606.5	8,868,311,637.1
Орлогын албан татвар	1,641,444,434.6	2,415,620,740.9
Хувь хүний орлогын албан татвар	695,076,114.1	856,002,937.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-44,474,216.7	-41,895,217.5
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчдийн орлогын албан татвар	446,029.4	307,011.6
ААН-ын орлогын албан татвар	990,396,507.8	1,346,018,243.8
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	255,187,765.8
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,432,240,077.8	1,692,198,401.5
Хөрөнгийн албан татвар	131,129,627.4	141,176,636.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,618,492,105.6	2,195,013,279.6
Онцгой албан татвар	519,721,527.5	754,090,177.8
Тусгай зориулалтын орлого	12,386,570.0	13,063,741.0
Гадаад үйл ажиллагааны орлого	512,351,193.0	684,321,383.3
Бусад татвар, төлбөр, хураамж	1,242,176,070.6	972,827,276.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,041,774,345.8	841,018,010.9
Газрын төлбөр	61,125,077.2	66,662,717.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	68,428,084.3	57,492,615.1
Бусад татвар	70,848,563.3	7,653,933.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,215,279,421.6	11,572,381,189.4
Нийтлэг татварын бус орлого	13,134,794,995.7	11,511,313,195.0
Хөрөнгийн орлого	23,417,984.0	11,182,845.6
Тусламжийн орлого	56,136,889.0	44,707,850.4
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	929,552.9	5,177,298.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	862,995,483.8	181,256,955.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,002,879,612.1	16,219,214,185.5
УРСГАЛ ЗАРДАЛ	18,002,879,612.1	16,219,214,185.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,532,143,559.8	11,675,805,855.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,423,941,997.1	2,566,024,458.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,335,986.1	339,854,395.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,205,227.1	333,680,946.2
Хангамж, бараа материалын зардал	1,453,567,206.5	1,709,491,277.9
Нормативт зардал	264,226,241.4	279,740,693.4
Эд хогшил, урсгал засварын зардал	65,315,204.1	88,158,413.3
Томилолт, зочны зардал	70,319,971.8	73,995,176.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,182,432,246.3	5,604,659,593.7
Бараа үйлчилгээний бусад зардал	459,799,479.4	680,200,901.5
ХҮҮ	1,498,912,254.7	1,408,246,825.6
ТАТААС	246,915,741.7	236,308,579.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,724,908,055.9	2,898,852,924.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,185,336,899.8	4,402,735,596.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	103,940,345.3	69,288,298.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,855,921,054.3	2,070,488,802.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,855,921,054.3	2,070,488,802.9
Дотоод эх үүсвэрээр	1,855,198,002.8	2,069,536,870.3
Гадаад эх үүсвэрээр	723,051.5	951,932.6



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,751,980,709.0	-2,001,200,504.3
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-785,002,669.0	-2,096,428,646.9
Бусад эх үүсвэр	6,220,530,204.9	2,175,548,304.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	560,398,532.2	1,006,490,403.6
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	4,597,059,093.3	1,987,667,715.9
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,848,075,248.4	1,277,818,831.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	648,353,521.8	305,106,445.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,672,224,305.9	4,320,577,827.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,320,577,827.7	4,625,684,273.4



АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим юм.

Төрийн аудитын байгууллага Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2017 оны аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,164.5 тэрбум төгрөгийн 2.0 хувь буюу 243.3 тэрбум төгрөгөөр тогтоолоо.

Төлөвлөлтийн үе шатанд тооцоолсон үнэ цэнээр материаллаг байдлын суурийг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн 15,471.1 тэрбум төгрөгийн нийт зардалтай харьцуулахад 3,306.6 тэрбум төгрөгийн хэлбэлзэлтэй байгаа нь материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагатай болсон. Материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоход 309.4 тэрбум төгрөг болж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХҮРЭЭ БА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД АРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь заалтын дагуу Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 12-1/2968 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн ерөнхийлөн захирагч хооронд үүссэн 37,478.9 тэрбум төгрөгийн орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээ, өглөг, авлагыг цэвэрлэж тайлагнасан;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 55 ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4782 төсвийн байгууллага, төрийн сан, Засгийн газрын 23 тусгай сан, 539 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 156 төсөл хөтөлбөр, 884 хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан болон зардлын тайлан нийт 6439 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй зөвхөн 90-100 хувийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэжээ.

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузал сууриар бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-ыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргасан байна.

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	



ягтлан бодох бүртгэлийн зарчим

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгөнд бэлэн мөнгө болон хугацаагүй хадгаламж, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, үнэ цэний өөрчлөлтийн эрсдэл багатай, мөнгөний дүнд чөлөөтэй хувирдаг, түргэн хөрвөх чадвартай богино хугацаат хөрөнгө оруулалтыг тайлагнажээ.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны Монголбанк дахь үлдэгдэл;
- Төрийн сангийн орлогын ерөнхий дансдын үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, сангуудын төрийн сангийн харилцах данс дахь үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, төсөл, сангийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Касст байгаа бэлэн мөнгө;
- Замд яваа мөнгөн хөрөнгө;
- Хадгаламж;
- 3 сар хүртэлх хугацаатай үнэт цаас;

Мөнгөтэй адилтгах хөрөнгөд Хөгжлийн банк, Хөрөнгийн биржийн эзэмшиж буй түргэн хөрвөх чадвартай үнэт цаасыг бүртгэсэн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтад Монголбанкнаас гаргасан богино хугацаат үнэт цаасыг тайлагнасан байна.

Авлага

Авлага дансанд зээлээр үзүүлсэн ажил үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүний төлбөрийг нэхэмжлэн авах мөнгөн дүнг тайлагнасан байна.

Зээлийн авлага нь бусдад зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн төлөгдөөгүй үлдэгдлийн дүнг илэрхийлжээ.

Урьдчилгаа

Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнийг урьдчилан шилжүүлэх, ажлын хөлс, үйлчилгээний үнэд урьдчилан төлсөн урьдчилгаа болон урьдчилж төлсөн зардлуудыг хамруулсан байна.

Бараа материал

Бараа материалын байнгын системийн аргыг ашигладаг ба төсвийн байгууллагууд бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагадах зарчмаар тодорхойлсон байна.

Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний дуусаагүй болон шилжүүлээгүй ажлуудыг бараа материал дансанд тайлагнажээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалт

Төрийн өмчит хуулийн этгээд, олон улсын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагад оруулсан урт хугацаат хөрөнгө оруулалтуудыг хамруулсан байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”, 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн байна.



иет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд биет шинж чанаргүй, ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага, лиценз, эзэмших, ашиглах эрхийг бүртгэжээ.

Богино хугацаат өглөг

Богино хугацаат үнэт цаасны өр төлбөр, төсвийн байгууллага, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллагуудын нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаатай Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны төлбөр, гадаад хөнгөлөлттэй зээл, төсөл сан, төрийн өмчит хуулийн этгээдийн урт хугацаат зээл, хойшлогдсон өр төлбөрийг хамруулжээ.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Улсын төсвийн орлогыг УСНББОУС болон нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл зарчмын дагуу орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Зардал

Нягтлан бодох бүртгэлийн аккруэл зарчмын дагуу зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР**Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн 56,770.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 24.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө /сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдлийн нийт дүнд эзлэх хувь	Эцсийн үлдэгдлийн нийт дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	13,709,808.5	14,687,883.4	30.1	25.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,812,192.2	42,082,950.4	69.9	74.1
Нийт хөрөнгийн дүн	45,522,000.7	56,770,833.8	100.0	100.0
Нийт өр төлбөр	28,068,248.1	29,798,446.5	61.7	52.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,453,752.6	26,972,387.3	38.3	47.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	45,522,000.7	56,770,833.8	100.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 11,248.8 тэрбум төгрөгөөр өссөн нь 2018 онд үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ, газрын үнэлгээ хийгдэж эргэлтийн бус хөрөнгийн дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үлдэгдлийн дүнд эзлэх эргэлтийн бус хөрөнгө өмнөх оноос 4.2 пункт, цэвэр хөрөнгө, өмчийн дүн 9.2 пунктээр өссөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 16,187.2 тэрбум, нийт зарлага 15,471.1 тэрбум төгрөгөөр тайлагнагдаж нийт үр дүн 716.1 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нийт 705.8 тэрбум төгрөгийн ашигтай, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 688.0 тэрбум, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 1,209.3 тэрбум төгрөгийн тус тус эерэг /орлого нь зардлаасаа их/ үзүүлэлттэй гарсан байна. Төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 1,887.0 тэрбум төгрөгийн сөрөг /зардал нь орлогоосоо их/ үзүүлэлттэй гарсан нь 1,516.3 тэрбум төгрөгийн валютын ханшийн зөрүүний алдагдлаас шалтгаалжээ.

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын 2018 оны нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар засгийн газрын хувь оролцоо 9,518.6 тэрбум төгрөгөөр өссөн нь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ, газрыг үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2018 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн орлого 22,866.8 тэрбум, зарлага 22,561.7 тэрбум, цэвэр мөнгөн гүйлгээ 305.1 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоо нь 90 хувиас бага хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгээгүй;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж байгаа Э-тайлан цахим системд хоорондын тооцооны цэс шинээр үүсгэж давхардсан ажил гүйлгээг цэвэрлэх боломжийг бүрдүүлсэн ч байгууллагууд ажил гүйлгээг системд бүрэн бүртгэхгүй байгаагаас Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд давхардсан ажил гүйлгээ бүрэн цэвэрлэгдэх боломжгүй байна. Тухайлбал:
 - Төрийн сангийн санхүүгийн тайлан дахь 184.0 тэрбум төгрөгийн авлага, 1.2 тэрбум төгрөгийн богино хугацаат өглөг харилцагч байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж тайлагнагдаагүй;
 - ТӨБЗГ-аас тогтоолын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаагаас төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжүүлсэн нийт 2.2 тэрбум төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийн орлого, зардлын бүртгэл зөрүүтэй тайлагнагдсан.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

5.1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	55,936.9	46,887.3	-9,049.6	1.0
Банканд байгаа бэлэн мөнгө	3,195,537.6	3,366,148.4	170,610.8	72.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	11,410.4	12,670.1	1,259.7	0.3
Хадгаламж	1,057,692.9	1,199,978.4	142,285.5	25.9
Дүн	4,320,577.8	4,625,684.2	305,106.4	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	298,547.6	280,046.4	-18,501.2	6.1
Төсөл/сан	1,299,670.2	1,477,770.0	178,099.8	31.9
Төрийн сан	1,119,211.3	262,655.4	-856,555.9	5.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,603,148.7	2,605,212.4	1,002,063.7	56.3
Дүн	4,320,577.8	4,625,684.2	305,106.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 3,366.1 тэрбум төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 1,039.9 тэрбум төгрөг байна. Үүнээс 860.0 тэрбум төгрөг нь улсын ТЕЗ-дын, 33.3 тэрбум төгрөг нь орон нутгийн ТЕЗ-дын, 146.6 тэрбум төгрөг нь Төв төрийн сангийн үлдэгдэл байна.

Нийт 1,199.9 тэрбум төгрөгийн хадгаламжийн 25.8 хувь буюу 310.0 тэрбум төгрөг Монгол Улсын Хөгжлийн банкны, 36.6 хувь буюу 439.3 тэрбум төгрөг НДС-ийн, 34.7 хувь буюу 416.0 тэрбум төгрөг ЭМДС-ийн, 2.9 хувь буюу 34.6 тэрбум төгрөг Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ болон их дээд сургуулиудын хадгаламж эзэлж байна.

Тайлант онд хадгаламж 142.3 тэрбум төгрөгөөр өссөн нь ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2018 оны “Хөрөнгийн зохистой харьцаа тогтоох” тухай 14 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 416.0 тэрбум төгрөгийг арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулсантай холбоотой байна.

Хүснэгт №3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, төсвийн захирагчдаар /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төв төрийн сан	929,950.9	187,320.3	-742,630.6	4.1
Улсын ТЕЗ	1,947,922.9	2,826,385.8	878,462.9	61.1
Орон нутгийн ТЕЗ	345,026.0	218,734.5	-126,291.5	4.7
НДС	1,097,678.0	865,729.1	-231,948.9	18.7
ЭМДС	-	527,514.5	527,514.5	11.4
Дүн	4,320,577.8	4,625,684.2	305,106.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд татан буугдсан Капитал банканд байсан төрийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэл 245.4 тэрбум төгрөг нь төлөгдөх эсэх нь тодорхойгүй байна.

Хүснэгт №4. Капитал банкин дахь харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл /сая төгрөг/

Төсөв захирагчдын нэр	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	
	2018.12.31	2019.04.08
Ерөнхий сайд /Монголын Цахилгаан Холбоо ХК/	8.1	15.8
Батлан хамгаалах сайд /Бөртэ ТӨҮГ/	0.1	0.1
Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд/АШУҮИС, МУБИС/	6,360.0	6,000.0
Зам, тээврийн хөгжлийн сайд /Орхон АЗЗА, Ховд АЗЗА/	2.9	2.9
Эрчим хүчний сайдын харьяа ТӨҮГ-ууд	426.7	401.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /сангууд/	204.8	77.6
Нийгмийн даатгалын сан	105,303.6	105,370.1
Эрүүл мэндийн даатгалын сан	131,824.1	134,860.0

Сангийн сайдын харьяа ТӨҮГ-ууд /Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан/ Орон нутгийн төсөв захирагчид	560.6 757.4	1,833.7 757.4
Дүн	245,448.3	249,319.4

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

5.1.1. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 929.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 187.3 тэрбум төгрөг болж, 742.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	919,047.0	180,775.0	-738,272.0
Төгрөг	443,278.3	34,206.6	-409,071.7
Төрийн сан	427,868.0	17,814.1	-410,053.9
Монголбанк	7,858.8	8,339.9	481.1
Арилжааны банк	7,551.5	8,052.6	501.1
Гадаад валют	475,768.7	146,568.4	-329,200.3
Монголбанк	475,768.7	146,568.4	-329,200.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	10,903.9	6,545.3	-4,358.6
Нийт дүн	929,950.9	187,320.3	-742,630.6

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 21.8 хувийг төгрөгийн, 78.2 хувийг гадаад валютын харилцах дансдын үлдэгдэл эзэлж байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 929.9 тэрбум төгрөг байсан бол тайлант онд 7,666.9 тэрбум төгрөгийн орлого орж, 8,409.5 тэрбум төгрөг зарцуулж, 187.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны төлбөрт 1,766.9 тэрбум, Чингис, Димсам бондын үндсэн төлбөрт 273.1 сая ам.доллар буюу 667.0 тэрбум төгрөг төлөхөд төсвийн орлого хүрэлцээгүйгээс эхний үлдэгдлээс зарцуулжээ.

Хүснэгт №6. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Валютын төрөл	Валютын үлдэгдэл /мянган нэгж/	Монголбанкны 2018.12.31-ний хаалтын ханш	Эцсийн үлдэгдэл /сая төгрөг/
Төрийн сангийн харилцах /төгрөгөөр/				17,814.1
Гаалийн түр горим				17,814.1
Монголбанк дахь төгрөгийн харилцах				8,339.9
Банкны үйлчилгээний шимтгэл				1.4
Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа				2,748.9
Хувийн хэвшлийг дэмжих 2 дахь төслийн зээлийн эргэн төлөлт				2,687.6
Монголын ипотекийн зах зээлийн хөгжлийг дэмжих төсөл				2,901.4
Хүний хөгжил сан				0.6
Монголбанк дахь валютын харилцах				146,568.4
Улсын төсөв /доллар/	USD	48,538.3	2,642.92	128,282.7
Улсын төсөв /евро/	EUR	898.0	3,028.65	2,719.8
Улсын төсөв /иен/	JPY	650.2	23.94	15,565.9
Арилжааны банк дахь төгрөгийн харилцах				8,052.6
Улаанбаатар банк /тусламж/				641.8
Төрийн банк /Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны буцаалт/				7,410.8
Замд яваа мөнгөн хөрөнгө				6,545.3
Татварын ерөнхий газар				3,499.6
Гаалийн ерөнхий газар				3,045.7
Нийт дүн				187,320.3

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сан улсын төсвийн зарлагын эх үүсвэрийн дутагдал 853.2 тэрбум төгрөгийг төрийн сангийн нэгдсэн данснаас бүрдүүлж санхүүжүүлсэн байна.

1.2. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,947.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,826.4 тэрбум төгрөг болж, 878.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төсөл/сангууд	ТӨҮГ	Нийт
Касст байгаа бэлэн мөнгө	1,017.3	5.8	45,487.9	46,511.0
Банканд байгаа бэлэн мөнгө	200,539.6	68,181.8	2,165,882.6	2,434,604.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	591.5	-	35.8	627.3
Хадгаламж	-	-	344,643.5	344,643.5
Дүн	202,148.4	68,187.6	2,556,049.8	2,826,385.8

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөтэй адилтгах хөрөнгөд Монгол Улсын Хөгжлийн банк, Хөрөнгийн биржийн эзэмшиж буй 716.2 тэрбум төгрөгийн 3 сар хүртэлх хугацаатай, түргэн хөрвөх чадвартай үнэт цаасыг бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн тооллого тооцоог бодоогүй 3.0 тэрбум төгрөг. /Тухайлбал: УУХҮС 2.9 тэрбум, ХНХС 0.05 тэрбум, БСШУСС 0.04 тэрбум төгрөг/;
- Жижиг мөнгөн сангийн гүйлгээг дутуу тайлагнасан зэрэг 0.2 тэрбум төгрөг /ЭМС 0.12 тэрбум, Шадар сайд 0.03 тэрбум, ЗТХС 0.01 тэрбум, ХНХС 0.01 тэрбум төгрөг/;
- Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй 0.2 тэрбум төгрөг /ЭМС 0.17 тэрбум, УУХҮС 0.01 тэрбум/ зэрэг нийт 3.4 тэрбум төгрөгийн зөрчил байна.

5.1.3. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 345.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 218.7 тэрбум төгрөг болж, 126.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	Төсөл/сангууд	ОНӨҮГ	Нийт
Касст байгаа бэлэн мөнгө	64.3	0.1	0.6	311.3	376.3
Банканд байгаа бэлэн мөнгө	76,936.1	69,837.6	17,235.7	48,851.3	212,860.7
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	5,497.5	-	-	5,497.5
Дүн	77,000.4	75,335.2	17,236.3	49,162.6	218,734.5

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, шилжүүлсэн төлбөрийн баримтгүй, албан томилолтын тайлан, гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэн, хүлээн авсан актгүй мөнгөн хөрөнгө зарцуулсан, зөрүүтэй тайлагнасан зэрэг 5.5 тэрбум төгрөг /Архангай аймаг 0.1 тэрбум, Баян-Өлгий аймаг 0.1 тэрбум, Дархан-Уул аймаг 0.8 тэрбум, Дорноговь аймаг 0.1 тэрбум, Хэнтий аймаг 0.3 тэрбум, Орхон аймаг 0.6 тэрбум, Ховд аймаг 0.6 тэрбум, Сүхбаатар аймаг 0.8 тэрбум, Завхан аймаг 0.3 тэрбум, Өвөрхангай аймаг 0.1 тэрбум, Сэлэнгэ аймаг 0.1 тэрбум, Хөвсгөл аймаг 0.1 тэрбум, Нийслэл 1.5 тэрбум төгрөг/;
- Мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, банкны үлдэгдлийг баталгаажуулаагүй, үлдэгдлийг тайланд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан, бэлэн мөнгө дутагдсан, үлдэгдэлгүй данснаас зарлагын гүйлгээ гаргасан зэрэг 0.8 тэрбум төгрөг /Баян-Өлгий аймаг 0.1 тэрбум, Булган аймаг 0.1 тэрбум, Говьсүмбэр аймаг 0.1 тэрбум, Дорноговь аймаг 0.3 тэрбум, Ховд аймаг 0.1 тэрбум, Нийслэл 0.1 тэрбум төгрөг/;
- Баян-Өлгий аймгийн ИТХ-ын даргын нөөц хөрөнгө гэсэн зардлын 30.0 сая төгрөгийн төсөв баталж зарцуулсан, Орхон аймгийн төсвийн 24 байгууллагад ажилчдын цалин хөлс олгох зориулалттай харилцах данс /Хас банк-22, Төрийн банк-1, Капитал банк-1/ арилжааны банканд зөвшөөрөлгүйгээр нээсэн зэрэг зөрчил илэрлээ.

1.4. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,097.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 865.7 тэрбум төгрөг болж, 231.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	647,087.9	426,394.2	-220,693.7	49.3
Төрийн сангийн харилцах	104,203.2	1,249.7	-102,953.5	0.2
Арилжааны банкны харилцах	542,884.7	425,142.3	-117,742.4	49.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	2.2	2.2	0.0
Хадгаламж	450,590.0	439,335.0	-11,255.0	50.7
Нийт дүн	1,097,677.9	865,729.2	-231,948.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

НДС-ийн чөлөөт үлдэгдлээс хадгаламж хэлбэрээр байршиж буй мөнгөн хөрөнгө 439.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 11.3 тэрбум төгрөгөөр буурсан нь ЭМДС-д 167.0 тэрбум төгрөгийн хадгаламж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №10. Арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж /сая төгрөг/

Банкны нэр	ҮОМШӨ-ний даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	Дүн
Улаанбаатар хотын банк	21,566.0	46,789.0	68,355.0
Голомт банк	100,400.0	180.0	100,580.0
Капитал банк	2,400.0	-	2,400.0
Капитрон банк	11,000.0	5,900.0	16,900.0
Төрийн банк	49,000.0	1,000.0	50,000.0
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	26,800.0	5,030.0	31,830.0
Хаан банк	54,000.0	-	54,000.0
Худалдаа хөгжлийн банк	100.0	50.0	150.0
Чингис хаан банк	69,120.0	1,000.0	70,120.0
Тээвэр хөгжлийн банк	41,000.0	4,000.0	45,000.0
ДҮН	375,386.0	63,949.0	439,335.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламжийн хүүг НДҮЗ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор 15.0 хувь болгосон ба 2018 оны 3 дугаар сард 13.0 хувь, 11 дүгээр сард 14.0 хувь болж хүүгийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

Хүснэгт №11. Хадгаламжийн хүүгийн өөрчлөлт

Монгол банкны бодлогын хүү		Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор	
Огноо	Хүүгийн хэмжээ	Огноо/ тогтоолын дугаар	Хүүгийн хэмжээ
2016.12.19	14%	2016.12.15 №33	15%
2017.03.17	14%		
2017.06.15	12%		
2017.12.25	11%		
2018.03.23	10%	2018.08.17 №09	13%
2018.11.28	11%	2018.12.24 №13	14%

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл

5.1.5. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 527.5 тэрбум төгрөг нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 11.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт № 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь
Харилцах данс	-	111,514.6	21.1
Төрийн сангийн харилцах	-	639.5	
Арилжааны банкны харилцах	-	110,875.1	
Хадгаламж	-	416,000.0	78.9
Нийт дүн	-	527,514.6	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 78.9 хувийг арилжааны 7 банканд хадгаламж хэлбэрээр айршуулж 35.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олжээ.

Хүснэгт № 13. Арилжааны банкуудад байршуулсан хадгаламж /сая төгрөг/

Банкны нэр	Хүүгийн хэмжээ	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь
Улаанбаатар банк	11%	55,000.0	13.2
Хаан банк	13%	65,000.0	15.6
Капитал банк	12%	128,000.0	30.8
Төрийн банк	13%	35,000.0	8.4
Капитрон банк	11%	68,000.0	16.4
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	12%	35,000.0	8.4
Голомт банк	12%	30,000.0	7.2
Дүн		416,000.00	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

5.2. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 352.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 579.2 тэрбум төгрөг болж, 226.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 14. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Боловсролын зээлийн сан	7,100.0	1,416.1	-5,683.9
МИАТ	-	42,170.6	42,170.6
Монголын Цахилгаан холбоо ХК	-	5,831.5	5,831.5
Монгол Улсын Хөгжлийн банк	-	28,394.8	28,394.8
Монголын хөрөнгийн бирж	1.0	1.0	-
Төрийн банк	343,367.5	501,417.2	158,049.7
ХАА-н давхар даатгал	2,462.7	-	-2,462.7
Дүн	352,931.2	579,231.2	226,300.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлан оны эцэст Боловсролын зээлийн сангаас Засгийн газрын 2016 оны 111, 2017 оны 176 дугаар тогтоолын дагуу арилжааны банкнуудад байршуулсан "Оюутны хөгжлийн зээл"-ийн хөтөлбөрийн эх үүсвэрийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд 196 хоногийн хугацаатай 1.6 тэрбум төгрөгийн хямдралтай 30.0 тэрбум төгрөгийн, Төрийн банкны богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд 28 болон 196 хоногийн хугацаатай 3.6 тэрбум төгрөгийн хямдралтай 505.0 тэрбум төгрөгийн Төв банкны үнэт цаас тус тус бүртгэлтэй байна.

Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 57.0 тэрбум төгрөг байснаас тайлант онд Засгийн газрын бондыг буцаан худалдаж, үлдэгдэлгүй болсон байна.

5.3. АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 4,257.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,598.5 тэрбум төгрөг болж, 341.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 15. Авлага, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,612.1	2,050.1	438.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	309,089.5	331,882.8	22,793.3
Татаас, санхүүжилтийн авлага	5,180.4	13,136.0	7,955.6
Зээлийн хүүгийн авлага	223,285.4	181,938.9	-41,346.5
Дансны авлага /ТӨҮГ/	864,408.7	634,679.8	-229,728.9
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	34,528.8	55,883.3	21,354.5
Бусад авлага	820,310.8	1,100,558.9	280,248.1
Зээлийн авлага	1,999,093.3	2,278,368.8	279,275.5
Дүн	4,257,509.0	4,598,498.6	340,989.6

Гүнээс, байгууллагын төрлөөр

Гөрийн өмчит үйлдвэрийн газар	1,715,668.2	1,691,427.6	-24,240.6
Төрийн сан	1,255,592.9	1,436,093.7	180,500.8
Төсөвт байгууллага	1,020,759.4	1,192,864.3	172,104.9
Төсөл/Сан	265,488.5	278,113.0	12,624.5
Дүн	4,257,509.0	4,598,498.6	340,989.6

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бусад авлага болон зээлийн авлага өссөн нь Төрийн сан байгууллагаас авах авлага 140.8 тэрбум төгрөгөөр, Монгол Улсын Хөгжлийн банк дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага 118.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

5.3.1. Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын эхний үлдэгдэл 1,250.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,430.4 тэрбум төгрөг болж 179.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 80.7 хувь буюу 1,154.4 тэрбум төгрөг нь гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага байна.

Хүснэгт № 16. Төв төрийн сангийн авлага /сая төгрөг/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	1,865.4	2,724.5	859.1
Банкны байгууллагаас авах авлага	80,564.9	81,305.1	740.2
Засгийн газрын түвшин хоорондын авлага	303.2	303.2	-
Бусад байгууллагаас авах авлага	153,161.4	183,630.7	30,469.3
Хувь хүмүүсээс авах авлага	11.1	11.1	-
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	7,921.7	8,000.9	79.2
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,006,973.8	1,154,458.3	147,484.5
Дүн	1,250,801.5	1,430,433.8	179,632.3

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан

Тайлант онд авлага 419.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 619.4 тэрбум төгрөгөөр хасагдсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 158.2 тэрбум төгрөгийн дараах авлага найдваргүй болох эрсдэлтэй байна. Үүнд:

- Анод, Зоос, ХОТШ, Ард банкнуудын 82.1 тэрбум;
- Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны 6787 зээлдэгчид холбогдох 29.4 тэрбум, татан буугдсан 26 хадгаламж зээлийн хоршоодын 20.6 тэрбум;
- ТОСК ХХК, Нефть импорт концерн, Төмөрлөгийн үйлдвэрийн 23.6 тэрбум;
- Бусад 16 харилцагчдын 2.5 тэрбум төгрөгийн авлага байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 1,006.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,154.4 тэрбум төгрөг болж, 147.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд дамжуулан зээлийн ашиглалт 184.0 тэрбум төгрөг гарснаас 2.1 тэрбум төгрөгийн Дэлхийн банкны 3 төсөл, Азийн хөгжлийн банкны 1 төсөл шинээр хэрэгжиж эхэлсэн ба 5 төсөл хэрэгжиж дууссан байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөр 35.6 тэрбум төгрөг эргэн төлөгдөж, зээлийн хүүгийн орлого 12.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дээрх дамжуулан зээл нь 15 донор байгууллагаас 9 төрлийн валютаар олгосон бөгөөд тайлант онд 112.7 тэрбум төгрөгийн валютын ханшийн зөрүүний алдагдал хүлээсэн байна.

Хүснэгт № 17. Гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээсэн ашиг, алдагдал /сая төгрөг/

Валют	2017 он		2018 он	
	ашиг	алдагдал	ашиг	алдагдал
AED	811.7	-	-	-2,803.8
CHF	-	-729.9	-	-2,888.1
CNY	-	-904.1	-	-939.2



EUR	-	-8,997.3	-	-4,527.8
JPY	-	-1,720.1	-	-21,692.6
KRW	-	-1,657.4	-	-789.2
KWD	973.2	-	-	-6,789.6
SDR	-	-10,255.2	-	-22,436.2
USD	11,656.9	-	-	-49,838.6
ДҮН	13,441.8	-24,264.0	-	-112,705.1

Эх сурвалж: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэс

Дамжуулан зээлийн 848.5 тэрбум төгрөгийн авлага эргэн төлөлт хийгдээгүй /ханшийн зөрүүгээр 69.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн/ олон жил болсон, 349.5 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит байгууллагуудын эргэн төлөлт хийгдэхгүй байгаа, хугацаа хэтэрсэн 144.4 тэрбум;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд 1991-1996 онуудад дамжуулан зээлийн гэрээгүй олгосон зээл 293.6 тэрбум;
- Санхүүгийн тайланд бүртгэлгүй 297.7 тэрбум /Зам, тээврийн хөгжлийн яам 199.5 тэрбум, Эрчим хүчний хөгжлийн төвийн 98.2 тэрбум/, үүнээс 119.1 тэрбум төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн;
- Улаанбаатар Төмөр зам ХНН-ийн хугацаа хэтэрсэн 77.4 тэрбум;
- Нийслэлийн тээврийн газарт олгосон зээлээс төсвийн хөрөнгө оруулалтад тооцох тухай Засгийн газрын тогтоолтой 23.9 тэрбум;
- Төрийн холбооны газрын хугацаа хэтэрсэн 6.6 тэрбум;
- Анод банканд олгосон зээл 2.7 тэрбум;
- Шүүхийн шийдвэрээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 2.2 тэрбум төгрөг.

Орон нутгийн ТЕЗ-аар дамжуулан олгосон нийт 315.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэл валютын ханшийн зөрүүгээс 12.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд Нийслэлийн ТЕЗ-аар дамжуулан 29.0 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт гарсан байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад 1991-1996 онд олгосон зээл валютын ханшийн зөрүүгээр 19.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 293.6 тэрбум төгрөгийн найдваргүй зээлийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-д зээлийн эргэн төлөлтийг хугацаандаа хийхгүй байгаа хуулийн этгээдээс үл маргах журмаар гаргуулах талаар тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй;
- Дамжуулан зээлийн авлагыг зээл ашиглагч байгууллагын хөрөнгө оруулалтад тооцох тухай Засгийн газрын холбогдох тогтоолтой 23.9 тэрбум, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 2.2 тэрбум нийт 26.1 тэрбум төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй;
- Зээл ашиглагч байгууллагыг өөрчлөн зохион байгуулахдаа санхүүгийн тайлан дахь авлага, өр төлбөрийг баталгаажуулж дараагийн байгууллагад шилжүүлэхгүй байгаагаас 297.7 тэрбум төгрөгийн авлага зээл ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй;
- Татан буугдсан Капитал банканд 3.5 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн авлага барагдах нь тодорхойгүй байна.

5.3.2. Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 1,020.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,192.9 тэрбум төгрөг болж, 172.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 18. Төсөвт байгууллагын авлага /сая төгрөг/

Төсөвт байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид	876,354.7	1,051,292.6	174,937.9
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	144,404.7	141,571.8	-2,832.9
ДҮН	1,020,759.4	1,192,864.4	172,105.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд улсын төсвийн байгууллагуудын авлага 174.9 тэрбум төгрөгөөр өссөн нь Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын алба дампуурсан хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгуулагч нараас авах 35.3 тэрбум төгрөгийн авлагыг санхүүгийн



айланд залруулж бүртгэсэн, ХЭДС-ийн 25.2 тэрбум, Хөдөө аж ахуйн хөдөөгийн төсөл 23.9 тэрбум, ЖДҮХС-ийн 30.2 тэрбум, ТЭДС-ийн 17.6 тэрбум төгрөгөөр байгууллагаас авах авлага, Боловсролын зээлийн сангийн 31.8 тэрбум төгрөгөөр сургалтын зээлийн авлага өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- БСШУСС-ын харьяа байгууллагууд 129.3 тэрбум төгрөгийн авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй;
- Нийслэлийн харьяа байгууллагууд 5.3 тэрбум төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тайлагнаагүй;
- Зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 68.5 тэрбум төгрөгийн авлагатай /ХАА-н бага оврын трактор худалдан авах төсөл 17.0 тэрбум, Мал хамгаалах сан 2.6 тэрбум, ТЭДС 36.0 тэрбум, Ховд аймаг 4.4 тэрбум, Архангай аймаг 2.1 тэрбум, Дундговь аймаг 2.0 тэрбум, Сэлэнгэ аймаг 1.6 тэрбум, Дорнод аймаг 1.4 тэрбум, Өмнөговь аймаг 1.4 тэрбум төгрөг/;
- Тооцоо нийлсэн актаар 23.3 тэрбум төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй /ЖДҮХС 2.9 тэрбум, ТЭДС 6.5 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 10.8 тэрбум, Төв аймаг 1.8 тэрбум, Сүхбаатар аймаг 1.3 тэрбум төгрөг/;
- Татан буугдсан Капитал банканд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 1.6 тэрбум төгрөгийн авлага барагдах нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд байна.

5.3.3. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нийт авлагын эхний үлдэгдэл 1,715.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,691.4 тэрбум төгрөг болж 24.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 19. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага /сая төгрөг/

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит үйлдвэрийн газар	1,672,523.3	1,645,649.8	-26,873.5
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	43,144.9	45,777.8	2,632.9
ДҮН	1,715,668.2	1,691,427.6	-24,240.6

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төрийн өмчит үйлдвэрийн газрын авлага буурсан нь Монгол Улсын Хөгжлийн банк 41.8 тэрбум, Диспетчерийн үндэсний төв 23.9 тэрбум, Хадгаламж, даатгалын корпораци 11.2 тэрбум төгрөгөөр дансны авлагыг барагдуулсантай холбоотой байна. Харин Эрдэнэс Тавантолгой ХК 15.2 тэрбум, ИНЕГ 10.8 тэрбум, Төрийн банк 9.4 тэрбум, ТОСК ХХК 7.5 тэрбум, Дорноговь аймаг 1.6 тэрбум, Орхон аймаг 1.0 тэрбум төгрөгөөр авлага тус тус өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Харилцаа холбооны зохицуулах хороо 2-6 жилийн насжилттай 2.7 тэрбум төгрөгийн;
- ИНЕГ гадаадын дампуурсан авиа компаниас авах, 1998-2017 онд үүссэн 2.3 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

5.3.4. Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлагын эхний үлдэгдэл 123.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 126.5 тэрбум төгрөг болж, 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 20. Нийгмийн даатгалын сангийн авлага /сангийн төрлөөр, сая төгрөг/

Сангийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Нийт дүнд эзлэх хувь
Тэтгэврийн даатгалын сан	69,169.4	84,311.8	15,142.4	66.6
Тэтгэмжийн даатгалын сан	7,185.8	9,480.3	2,294.5	7.5
Ажилгүйдлийн даатгалын сан	1,600.5	2,022.5	422.0	1.6
ҮОМШӨ-ний даатгалын сан	16,650.3	9,480.3	-7,170.0	7.5
Эрүүл мэндийн даатгалын сан	28,951.9	21,109.6	-7,842.3	16.7
Үйл ажиллагааны авлага	129.9	84.3	-45.6	0.1
Дүн	123,687.8	126,488.8	2,801.0	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын сангийн авлагын үлдэгдэлд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 116.6 тэрбум төгрөг, бусад авлага 9.9 тэрбум төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын санд Нийгмийн даатгалын сангаас авах төр даатгалыг нь ариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх ЭМД-ийн шимтгэлийн 4.4 тэрбум төгрөгийн авлагыг балансаас балансад шилжүүлэн бүртгэж, оны эцсийн байдлаар 7.1 тэрбум төгрөгийн авлагатай байна.

5.4. УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 492.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 465.0 тэрбум төгрөг болж, 27.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 21. Урьдчилгаа данс /байгууллагын төрлөөр, сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/	Нийт дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	283,696.8	202,366.6	-81,330.2	43.5
Төрийн сан	64,995.2	64,995.2	0.0	14.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	127,762.5	182,272.5	54,510.0	39.2
Төсөл/ сан	15,954.0	15,377.4	-576.6	3.3
ДҮН	492,408.5	465,011.7	-27,396.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн 21.0 хувийг ЭХС, 18.8 хувийг УУХҮС, 14.0 хувийг Төв төрийн сан, 12.6 хувийг ЗТХС, 33.6 хувийг бусад улсын болон орон нутгийн ТЕЗ-д тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Эрчим хүчний яам 65.0 тэрбум төгрөгийн Мандалговь-Тавантолгой-Оюу Толгойн 2 хэлхээтэй 220 КВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 КВт-ын дэд станцын барилгыг бүртгэх шийдвэрийг ТӨБЗГ-ын зөвшөөрөл өгөөгүйгээс өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

5.5. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 6,006.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,930.0 тэрбум төгрөг болж, 923.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 22. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/	Нийт дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	1,109,767.1	1,193,085.9	83,318.8	17.2
Үнэт цаас	181,029.3	411,098.7	230,069.4	5.9
Урт хугацаат зээл	4,715,402.1	5,325,822.5	610,420.4	76.9
ДҮН	6,006,198.5	6,930,007.1	923,808.6	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	30,676.4	41,463.6	10,787.2	0.6
Төрийн сан	1,591,178.8	1,917,515.1	326,336.3	27.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,384,343.3	4,971,028.4	586,685.1	71.7
ДҮН	6,006,198.5	6,930,007.1	923,808.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 1,591.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,917.5 тэрбум төгрөг болж, 326.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ОУВС дахь 242.5 тэрбум төгрөгийн хувь оролцоо тайлант онд валютын ханшийн өөрчлөлтөөр 7.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 250.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

ОУВС-д оруулсан хувь оролцооны үр дүнд ОУВС-ийн Захирлуудын Зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар Монгол Улсад хэрэгжүүлэх нийт 314.5 сая нэгж зээлжих тусгай эрхтэй тэнцэх хөрөнгө бүхий “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэлэлцэн баталсантай холбоотойгоор 2018 онд 73.4 сая нэгж зээлжих тусгай эрхийг нэмэгдүүлсэн байна.

Орон сууцны урт хугацаат ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанканд шилжүүлсэн 231.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт 70.5 тэрбум төгрөгийн



авуу эрхтэй Ипотекийн зээлээр баталгаажсан бонд худалдан авч үндсэн төлбөрт 2.7 тэрбум эгрэгийг төвлөрүүлснээр 2018 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн дансанд 67.8 тэрбум төгрөгийн 678.0 мянган ширхэг Ипотекийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй бондын үлдэгдэл байна.

Төсөвт байгууллагын урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 30.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 41.5 тэрбум төгрөг болсон байна.

Төсөвт байгууллагын урт хугацаат хөрөнгө оруулалт дараах байдлаар нэмэгджээ. Үүнд: Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банканд 4.3 тэрбум, Зээлийн батлан даалтын санд 0.3 тэрбум, Монголын Цахилгаан Холбоо ХК-д 6.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус оруулсан байна.

Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоолын дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигч “Кореа телеком” корпорацид ногдох 10.3 сая ширхэг, хувь хүмүүст ногдох 7,572 ширхэг нийт 10.4 сая ширхэг хувьцааг нийт 6.2 тэрбум төгрөг /нэг ширхэг хувьцааны үнэ 595.5 төгрөг/-өөр Засгийн газар худалдан авснаар урт хугацаат хөрөнгө оруулалт, засгийн газрын хувь оролцоо дансанд тус тус бүртгэсэн байна. Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 10.4 сая ширхэг хувьцааг нийт 1.0 тэрбум төгрөг /нэг ширхэг хувьцааны нэрлэсэн үнэ 100.0 төгрөг/-өөр эздийн өмч дансанд бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сангийн сайдын багцын болон Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн санхүүгийн тайланд 10.4 сая ширхэг хувьцааг нийт 1.0 тэрбум төгрөг /нэг ширхэг хувьцааны нэрлэсэн үнэ 100.0 төгрөг/-өөр эздийн өмч дансанд давхар бүртгэсэн байна.

ТӨҮГ болон ОНӨҮГ-ын урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 4,384.3 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 4,971.0 тэрбум төгрөг болж, 586.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: *Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК 7.6 тэрбум, Төрийн банкны 503.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.*

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт тайлант онд 7.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгуулагчдын хураамжийн орлогыг Арилжааны 9 банканд хадгаламж хэлбэрээр байршуулсан байна. Тус компани нийт 46.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд урьд оны хадгаламжийн хүүгийн орлогоос 6.1 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

Тайлант хугацаанд Төрийн банкны урт хугацаат хөрөнгө оруулалт нийт 503.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь үнэт цаас худалдан авч, иргэд, аж ахуйн нэгжид урт хугацаат зээлийг олгосноос шалтгаалан нэмэгдсэн байна.

5.6. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,684.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,564.0 тэрбум төгрөг болж, 120.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 23. Бараа материал /сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Эзлэх хувь
Төсөвт байгууллага	794,659.0	774,317.5	-20,341.5	49.5
Төсөл/ сан	4,424.6	4,004.7	-419.9	0.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	884,953.9	785,693.6	-99,260.3	50.2
ДҮН	1,684,037.5	1,564,015.8	-120,021.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт бараа материалын эхний үлдэгдэл 1,491.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,365.9 тэрбум төгрөг болж 125.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн /УУХҮС 0.1 тэрбум, ХНХС 0.02 тэрбум, БСШУСС 0.3 тэрбум ХЗДХС 0.04 тэрбум төгрөг/;
- Тооллого хийгээгүй, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй /БХС 0.2 тэрбум, Стандарт, хэмжил зүйн газар 0.3 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 0.1 тэрбум, Нийслэл 0.4 тэрбум, Төв аймаг 0.1 тэрбум төгрөг/;
- Бараа материалын үлдэгдэлд 2014 оноос өмнө худалдан авсан ашиглалтгүй бараа материал байна. /Мэдээлэл холбооны сүлжээ ХХК 27.0 сая төгрөг/

Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,455.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,698.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж 243.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: ЗТХС-ын багцад хэрэгжиж байгаа дуусаагүй болон шилжүүлээгүй хөрөнгө оруулалтын 1,133.3 тэрбум төгрөгийн ажлууд нийт үлдэгдлийн 42 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд хөнгөлөлттэй зээлээр бэлтгэсэн 57.0 тэрбум төгрөгийн 65 ширхэг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулах тоног төхөөрөмж ашиглагдахгүй, данс бүртгэлд он дамжин үлдэгдлээр тайлагнагдаж байна.

5.7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 25,806.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 35,152.9 тэрбум төгрөг болж, 9,346.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 24. Үндсэн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	2,254.4	33,357.1	31,102.7	0.1
Биет хөрөнгө	13,678,167.4	18,972,094.1	5,293,926.7	54.0
Биет бус хөрөнгө	11,581,531.0	15,342,471.1	3,760,940.1	43.6
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	544,040.9	805,021.1	260,980.2	2.3
Дүн	25,805,993.7	35,152,943.4	9,346,949.7	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	9,975,112.5	16,486,362.1	6,511,249.6	46.9
Төсөл/ сан	40,264.5	166,756.1	126,491.6	0.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	15,790,616.7	18,499,825.2	2,709,208.5	52.6
Дүн	25,805,993.7	35,152,943.4	9,346,949.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө 9,346.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн болон төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, төсөл хөтөлбөр, бусад байгууллагуудаас хандив тусламжаар авсан хөрөнгө нийт 3,515.1 тэрбум, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу 56799 үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлсэн 3,522.7 тэрбум, 10891 байршил дахь газрыг 3,898.6 тэрбум төгрөгөөр үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ, эзэмших, ашиглах эрхтэй газрыг үнэлж бүртгэхдээ буруу дансанд бүртгэсэн 13.7 тэрбум, шинээр худалдан авсан, хандив тусламж, балансаас балансад болон данс хооронд шилжүүлэн бүртгэсэн хөрөнгийн хөдөлгөөнийг төсвийн байгууллагууд Э-тайлан цахим системд буруу шивж нэгтгүүлсэн 260.5 тэрбум, нийт 274.2 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 268.7 тэрбум төгрөгийн алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэсэн.

5.7.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 21,750.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 28,630.7 тэрбум төгрөг болж, 6,880.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: ЗТХС 2,644.7 тэрбум, БСШУСС 1,105.4 тэрбум, ЭХС 677.0 тэрбум, БХС 560.6 тэрбум, ЭМС 503.5 тэрбум, ХЗДХС 314.2 тэрбум, ГХС 279.5 тэрбум, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 253.4 тэрбум төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн байна.

үснэгт № 25. Үндсэн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	1,889.8	33,356.3	31,466.5	0.1
Биет хөрөнгө	9,662,553.6	13,714,061.4	4,051,507.8	47.9
Биет бус хөрөнгө	11,550,948.4	14,091,480.3	2,540,531.9	49.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	535,221.8	791,838.0	256,616.2	2.8
Дүн	21,750,613.6	28,630,736.0	6,880,122.4	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	6,672,875.6	11,403,233.3	4,730,357.7	39.8
Төсөл/ сан	39,667.0	165,227.7	125,560.7	0.6
ТӨҮГ	15,038,071.0	17,062,275.0	2,024,204.0	59.6
Дүн	21,750,613.6	28,630,736.0	6,880,122.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- ТӨБЗГ болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын зөвшөөрөлгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгийг бэлтгэсэн, данс бүртгэлд тусгасан, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн 1.6 тэрбум төгрөг /ХЗДХС 0.5 тэрбум, Шадар сайд 0.4 тэрбум, ГХС 0.3 тэрбум, ЭХС 0.2 тэрбум, БСШУСС 0.1 тэрбум, ЭМС 0.1 тэрбум төгрөг/;
- Худалдаж авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, ангилал буруу бүртгэсэн 39.6 тэрбум төгрөг /УУХҮС 37.1 тэрбум, ЭМС 0.7 тэрбум, Шадар сайд 0.4 тэрбум, БОАЖС 0.4 тэрбум, ЭХС 0.4 тэрбум, ХЗДХС 0.3 тэрбум, Ерөнхий сайд 0.1 тэрбум, БСШУСС 0.1 тэрбум, ГХС 0.1 тэрбум төгрөг/;
- Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгө дутагдсан 16.5 тэрбум төгрөг /БСШУСС 16.2 тэрбум, Сангийн сайд 0.1 тэрбум, УУХҮС 0.1 тэрбум, ЭМС 0.1 тэрбум төгрөг/;
- ТЕЗ-дын харьяа байгууллагуудын эзэмшил бүхий 566 байршил газар гэрчилгээгүй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, улсын тусгай хамгаалалттай бүсэд байршилтай, маргаантай шалтгаанаар дахин үнэлгээнд хамрагдаагүй зэрэг зөрчил байна.

5.7.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,055.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,522.2 тэрбум төгрөг болж, 2,466.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 26. Үндсэн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	364.6	0.8	-363.8	0.0
Биет хөрөнгө	4,015,613.8	5,258,032.7	1,242,418.9	80.6
Биет бус хөрөнгө	30,582.6	1,250,990.8	1,220,408.2	19.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	8,819.1	13,183.0	4,363.9	0.2
Дүн	4,055,380.1	6,522,207.3	2,466,827.2	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	3,302,236.9	5,083,128.6	1,780,891.7	77.9
Төсөл/ сан	597.6	1,528.4	930.8	0.1
ОНӨҮГ	752,545.6	1,437,550.3	685,004.7	22.0
Дүн	4,055,380.1	6,522,207.3	2,466,827.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн, биетээр хүлээн аваагүй хөрөнгийг бүртгэлд тусгасан, акталсан хөрөнгийг данснаас хасаагүй, байгууллагын данс бүртгэлд байгаа орон сууцыг иргэдэд өмчлүүлсэн, өөрийн өмчлөлийн бус хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, улсын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг бүртгэх шийдвэр гараагүй, данс бүртгэлд тусгаагүй зэрэг 33.5 тэрбум төгрөг /Архангай аймаг 0.1 тэрбум, Баянхонгор аймаг 0.01 тэрбум, Баян-Өлгий аймаг 1.9 тэрбум, Булган аймаг 1.2 тэрбум, Дархан-Уул аймаг 1.6 тэрбум, Дундговь аймаг 6.0 тэрбум, Говьсүмбэр аймаг 1.0 тэрбум, Орхон аймаг 10.7 тэрбум, Ховд аймаг 0.5 тэрбум, Сүхбаатар аймаг 0.4 тэрбум, Дорнод аймаг 9.2 тэрбум, Увс аймаг 0.02 тэрбум, Өмнөговь аймаг 0.3 тэрбум, Завхан аймаг 0.2 тэрбум, Өвөрхангай аймаг 0.1 тэрбум, Нийслэл 0.3 тэрбум төгрөг/;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, тооллогыг хийсэн боловч тооцоог бодоогүй, хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын дүн ашиглалтын картаас зөрүүтэй, хөрөнгө дутагдсан 1.8 тэрбум төгрөг /Нийслэл, Хэнтий аймаг, Өвөрхангай аймаг/;

- Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн, элэгдлийн зардлыг буруу тооцоолсон, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй, газрыг бүртгээгүй, буруу бүртгэсэн 17.8 тэрбум төгрөг /Архангай аймаг 0.1 тэрбум, Дархан-Уул аймаг 6.3 тэрбум, Хэнтий аймаг 1.2 тэрбум, Ховд аймаг 0.06 тэрбум, Увс аймаг 0.01 тэрбум, Өвөрхангай аймаг 8.0 тэрбум, Төв аймаг 1.9 тэрбум, Нийслэл 0.2 тэрбум төгрөг/;
- Аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газрын зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, шийдвэрийг хэрэгжүүлээгүй, үерийн улмаас ашиглалтгүй болсон, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч актлагдсан хөрөнгийг данснаас хасах талаар аймгийн ИТХ-ын шийдвэр гараагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр Засгийн газрын санг нэмэгдүүлсэн, худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн 2.8 тэрбум төгрөг /Архангай аймаг 0.1 тэрбум, Баян-Өлгий аймаг 1.9 тэрбум, Дархан-Уул аймаг 0.1 тэрбум, Дорноговь аймаг 0.1 тэрбум, Дундговь аймаг 0.1 тэрбум, Орхон аймаг 0.2 тэрбум, Хэнтий аймаг 0.2 тэрбум, Өвөрхангай аймаг 0.1 тэрбум төгрөг/;
- Байгууллагуудын эзэмшил бүхий 485 байршил газар гэрчилгээгүй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, улсын тусгай хамгаалалттай газар байршилтай, газрын маргаантай шалтгаанаар дахин үнэлгээнд хамрагдаагүй зэрэг зөрчил байна.

5.8. ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28,068.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 29,798.4 тэрбум төгрөг болж, 1,730.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №27. Нийт өр, төлбөр /дансны ангиллаар, сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	4,400,376.0	3,016,665.8	-1,383,710.2	10.1
Богино хугацаат үнэт цаас	1,407,116.0	77,254.8	-1,329,861.2	0.3
Богино хугацаат зээлийн өглөг	1,500,985.5	1,362,191.6	-138,793.9	4.6
Өглөг	1,043,667.2	1,181,540.6	137,873.4	3.9
Урьдчилж орсон орлого	448,607.3	395,678.8	-52,928.5	1.3
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	23,667,872.1	26,781,780.7	3,113,908.6	89.9
Урт хугацаат үнэт цаас	10,878,146.3	12,350,655.7	1,472,509.4	41.5
Урт хугацаат зээл	12,789,725.8	14,431,125.0	1,641,399.2	48.4
Нийт дүн	28,068,248.1	29,798,446.5	1,730,198.4	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>				
Төрийн сан	20,916,674.3	21,526,445.3	609,771.0	72.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,820,843.9	7,782,168.1	961,324.1	26.1
Төсөвт байгууллага	259,079.1	410,151.9	151,072.8	1.4
Төсөл сан	71,650.8	79,681.2	8,030.4	0.3
Нийт дүн	28,068,248.1	29,798,446.5	1,730,198.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,383.7 тэрбум төгрөгөөр буурсан боловч, урт хугацаат өр төлбөрийн дүн 3,113.9 тэрбум төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Богино хугацаат үнэт цаас 1,329.9 тэрбум төгрөгөөр буурсан нь Засгийн газрын дотоод бонд 1,767.7 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 132.6 тэрбум төгрөгөөр хасагдсантай, урт хугацаат үнэт цаас 1,472.5 тэрбум төгрөгөөр өссөн нь гадаад бонд 667.0 тэрбум төгрөгөөр эргүүлэн худалдан авсан, ханшийн зөрүүний алдагдал 632.9 тэрбум, Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаас 1,294.9 тэрбум, Төрийн банкны үнэт цаас 220.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй;
- Богино хугацаат зээл 138.8 тэрбум төгрөгөөр буурсан нь ТӨҮГ болон ОНӨҮГ 511.5 тэрбум, төсөл сан, төсвийн байгууллагууд 30.8 тэрбум төгрөгөөр зээлийн өглөг буурсантай, урт хугацаат зээл 1,641.4 тэрбум төгрөгөөр өссөн нь Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт 1,490.2 тэрбум, ханшийн зөрүүний алдагдал 834.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн төлбөрт 280.1 тэрбум төгрөгийг төлсөнтэй;
- Дансны өглөг өмнөх оноос 137.9 тэрбум төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын өглөг 157.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, ТӨҮГ болон ОНӨҮГ-ын өглөг 26.2 тэрбум төгрөгөөр буурсантай;
- Урьдчилж орсон орлого өмнөх оноос 52.9 тэрбум төгрөгөөр буурсан ТӨҮГ болон ОНӨҮГ-ын өглөг 78.1 тэрбум төгрөгөөр буурч, төрийн сан, төсөл сан, төсөвт байгууллагуудын өглөг 25.2 тэрбум төгрөгөөр өссөнтэй тус тус холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 89.9 хувь буюу 26,781.8 тэрбум төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзлж байгаа бөгөөд сүүлийн 6 жилийн ханшийн зөрүүний алдагдал гадаад бондын 2,584.5 тэрбум, гадаад зээлийн 2,529.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үнэт цаас, зээлийн өглөг

Нийт өр төлбөрийн 94.7 хувь буюу 28,221.2 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.

Хүснэгт №28. Үнэт цаас, зээлийн өглөг /сая төгрөг/

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төв төрийн сангийн өр төлбөрийн дүн	20,627,157.7	21,237,569.6	610,411.9	75.2
Дотоод бонд	3,250,985.2	1,579,851.6	-1,671,133.6	5.6
Гадаад үнэт цаас, бондын өглөг	17,376,172.5	19,657,718.0	2,281,545.5	69.6
Гадаад бондын өглөг	7,719,747.1	7,682,575.7	-37,171.4	27.2
ОУВС /үнэт цаас/	500,238.3	774,022.2	273,783.9	2.7
Гадаад зээл /хөнгөлөлттэй/	9,156,187.1	11,201,120.1	2,044,933.0	39.7
ТӨҮГ болон ОНӨҮГ-ын дүн	5,872,322.4	6,938,003.3	1,065,680.9	24.6
Үнэт цаасны өглөг	814,291.7	2,391,461.2	1,577,169.5	8.5
Зээлийн өглөг	5,058,030.7	4,546,542.1	-511,488.6	16.1
Бусад байгууллагын зээлийн өглөг	76,493.5	45,654.2	-30,839.3	0.2
Нийт дүн	26,575,973.6	28,221,227.1	1,645,253.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн өглөг 610.4 тэрбум, ТӨҮГ болон ОНӨҮГ-ын өглөг 1,065.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Үнэт цаас, зээлийн өглөгийн 75.2 хувь буюу 21,237.5 тэрбум төгрөгийг Төв төрийн сангийн өглөг эзэлж байна.

5.8.1. Төв төрийн сангийн өр төлбөр

Төв төрийн сангийн үнэт цаас, зээлийн өглөг

Хүснэгт №29. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өглөг /сая төгрөг/

Үзүүлэлт	Дотоод бонд	Гадаад бонд	Гадаад зээл	Дүн
Нэмэгдсэн дүн	3,157.5	629,859.2	2,325,087.2	2,958,103.9
Тухайн онд шинээр гаргасан бонд, авсан зээл			1,490,255.5	1,490,255.5
Ханшийн зөрүүний алдагдал	3,157.5	629,859.2	834,831.7	1,467,848.4
Хасагдсан дүн	1,900,330.1	667,030.6	280,154.2	2,847,514.9
Үндсэн төлбөр	1,767,698.0	667,030.6	280,154.2	2,714,882.8
Хөнгөлөлт	132,632.1			132,632.1
Хүүгийн төлбөр	221,549.6	520,767.2	170,978.8	913,295.6

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн бонд, урт хугацаат зээл дараах байдалтай байна. Үүнд:

Нэмэгдсэн:

- **Гадаад, дотоод, бондын өглөг:** Тайлант онд олон улсын зах зээл болон дотоодод бонд арилжаалаагүй бөгөөд ханшийн зөрүүний алдагдлаар дотоод бонд 3.2 тэрбум, гадаад бонд 629.8 тэрбум төгрөгөөр;
- **Гадаад зээл:** Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан авсан гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалт 1,490.3 тэрбум, ханшийн зөрүүний алдагдал 834.8 тэрбум нийт 2,325.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хасагдсан:

- **Дотоод бондын өглөг:** Төсвийн дутагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын бондын үндсэн төлбөр болон өндөр хүүтэй бондыг хугацаанаас нь өмнө худалдан авахад зориулж 1,667.4 тэрбум, 4000 айлын орон сууцны хөтөлбөрт зориулж гаргасан бондын төлбөрт 2.0 тэрбум, “Сайн” хөтөлбөрт зориулан гаргасан бондыг буцаан худалдан авахад 1.7 тэрбум,



Хүний хөгжил сангийн бондын төлбөрт 96.6 тэрбум, бондын хөнгөлөлтийн төлбөрт 132.6 тэрбум, нийт 1,900.3 тэрбум төгрөг төлсөн;

- Гадаад бондын өглөг: Чингис бонд 308.9 тэрбум, Димсам бонд 358.1 тэрбум нийт 667.0 тэрбум төгрөгийн бондыг эргүүлэн худалдан авсан;
- Гадаад зээлийн өглөг: Олон улсын байгууллагаас авсан урт хугацаат гадаад хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрт 280.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлжээ.

Мөн дотоод бонд 221.5 тэрбум, гадаад бонд 520.8 тэрбум, гадаад зээл 171.0 тэрбум нийт 913.3 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс төлсөн байна.

5.8.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр

ТӨҮГ болон ОНӨҮГ-ын өр төлбөрийн эхний үлдэгдэл 6,820.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 7,782.1 тэрбум төгрөг болж 961.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт өр төлбөрийн 89.1 хувь буюу 6,938.0 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.

Үнэт цаасны өглөгийн эхний үлдэгдэл 814.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,391.5 тэрбум төгрөг болж 1,577.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банкны 2,101.5 тэрбум, Төрийн банкны 290.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

Зээлийн өглөг оны эхэнд 5,058.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,546.5 тэрбум төгрөг болж, 511.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зээлийн үлдэгдэлд 98.3 хувь буюу 4,469.2 тэрбум төгрөгийг дараах байгууллагуудын зээл эзэлж байна. Тухайлбал: Монгол Улсын Хөгжлийн банк 1,024.6 тэрбум, Төрийн банк 2,350.6 тэрбум, МИАТ ТӨХК 171.5 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК 94.3 тэрбум, ТОСК ХХК 13.9 тэрбум, Хадгаламж даатгалын корпораци ХК 245.0 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 35.6 тэрбум, Эрдэнэс Монгол ХХК 81.3 тэрбум, ХАА-н давхар даатгал ХХК 20.2 тэрбум, Тавантолгойн түлш ХК 18.6 тэрбум, Мон-Атом ХХК 5.8 тэрбум, Шивээ овоо ХК 18.6 тэрбум, Зорчигч тээврийн нэгтгэл 22.2 тэрбум, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 15.8 тэрбум, Ус сувгийн удирдах газар 67.8 тэрбум, ЭХС-ын харьяа Цахилгаан дамжуулах болон түгээх станцууд 277.6 тэрбум төгрөг байна.

5.8.3. Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн эхний үлдэгдэл 259.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 410.1 тэрбум төгрөг болж, 151.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт өр төлбөрт улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр 82.3 хувь буюу 337.3 тэрбум, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч 17.7 хувь буюу 72.8 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд дансны өглөг 318.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба хувь хүмүүст өгөх өглөг 42.9 тэрбум, байгууллагад өгөх өглөг 94.5 тэрбум нийт 137.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: ХЗДХС 35.2 тэрбум, ХХААХҮС 32.9 тэрбум, БХБС 23.7 тэрбум, ЗТХС 21.0 тэрбум, ЭМС 3.7 тэрбум, БСШУСС 3.1 тэрбум, МУШС 2.7 тэрбум, ХНХС 2.6 тэрбум, Сангийн сайд 2.2 тэрбум, Нийслэлийн ТЕЗ 9.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХЗДХС-ын харьяа Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газрын өглөг 13.2 тэрбум, Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны өглөг 28.2 тэрбум төгрөгөөр өссөн нь хувь хүмүүст өгөх өглөг өмнөх оноос 42.9 тэрбум төгрөгөөр өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Мөн байгууллагад өгөх өглөг 94.5 тэрбум өссөн нь дараах өглөгүүд голлон өссөн байна. Тухайлбал:

- Төсөл, хөтөлбөрийн 8 нэгжийн өглөг 41.8 тэрбум;
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн өглөг 32.8 тэрбум;
- Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өглөг 7.5 тэрбум; /ЗТХС 3.9 тэрбум, БСШУСС 3.6 тэрбум/;
- ТЕЗ-дын харьяа 28 байгууллагуудын өглөг 4.6 тэрбум;



- Төрийн захиргааны төв 7 байгууллагуудын өглөг 1.0 тэрбум;
- Татварын хэлтсүүдийн өглөг 1.0 тэрбум;
- Сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн өглөг 1.3 төгрөгөөр тус тус өссөн байна.

5.8.4. Төсөл, сангийн өр төлбөр

Төсөл сангийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 71.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 79.7 тэрбум төгрөг болж 8.0 тэрбум төгрөгөөр өссөн. Тайлант онд НДС-ийн өр төлбөр 1.5 тэрбум, ЭМДС-ийн өр төлбөр 4.6 тэрбум, Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өглөг 2.1 тэрбум төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Нийт өр төлбөрийн 88.1 хувь буюу 70.2 тэрбум төгрөгийг дараах байгууллагуудын өр төлбөр эзэлж байна. Тухайлбал: Засгийн газрын өрийн баталгааны сан 35.4 тэрбум, Сангийн сайдын харьяа Тогтвортой амьжиргаа-2 төсөл 15.8 тэрбум, НДС 6.8 тэрбум, ЭМДС 4.6 тэрбум, ХХААХҮС-ын харьяа КР-2 төсөл 2.0 тэрбум, Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө 5.6 тэрбум төгрөг.

Аудитын илрүүлэлт:

- Урт хугацаат дотоод бондын хөнгөлөлт 15.5 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөрт ангилал буруу бүртгэсэн;
- Төсвийн захирагчдын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн үлдэгдлээс үүссэн он дамжсан 1.8 тэрбум төгрөгийг шийдвэрлээгүй;
- Анод банканд байршиж байсан улсын төсвийн орлогын дансны үлдэгдэл 253.5 сая төгрөгийн 2009 онд үүссэн өглөг байна. Өмнөх аудитаар тодорхой арга хэмжээ авах талаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Нэг жилийн дотор төлөгдөх гадаад зээлийг урт хугацаат зээлээс богино хугацаат зээлийн ангилалд шилжүүлэн бүртгээгүй;
- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 523.5 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгддэггүй, хугацаа хэтэрсэн өглөг, үүнээс 297.7 тэрбум төгрөгийн зээлийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй /Монголын төмөр зам ТӨХК 169.9 тэрбум, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ 123.9 тэрбум, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ 98.2 тэрбум, Улаанбаатар Төмөр зам ХНН 131.5 тэрбум төгрөг/ зэрэг зөрчил байна.

5.8.5. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 313.1 тэрбум, эцсийн үлдэгдэл 344.9 тэрбум төгрөг болж, 31.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №30. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөрийн дүн	152,110.5	173,880.4	21,769.9	50.4
Богино хугацаат зээлийн өглөг	10,775.1	2,407.8	-8,367.3	0.7
Богино хугацаат өглөг	89,654.2	125,531.9	35,877.7	36.4
Урьдчилж орсон орлого	51,681.2	45,940.7	-5,740.5	13.3
Урт хугацаат зээл	160,962.3	171,026.4	10,064.1	49.6
ДҮН	313,072.8	344,906.8	31,834.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээс орон нутагт дамжуулан зээлдүүлсэн Азийн хөгжлийн банкны 38, Дэлхийн банкны 6, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 2, Франц улсын 1, Испани улсын 1, нийт 48 төслийн хүрээнд 358.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Дамжуулан зээлдүүлэх 37 гэрээгээр 1994-2014 онд байгуулсан орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлд зориулан олгосон 299.6 тэрбум төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

5.8.6. Нийгмийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөрийн үлдэгдэл 22.7 тэрбум төгрөг болж 12.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн үлдэгдэлд богино хугацаат өр төлбөр 13.8 тэрбум төгрөг, урьдчилж орсон орлого 8.9 тэрбум төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөрийн үлдэгдэл 4.6 тэрбум төгрөг, үүнээс 2.5 тэрбум төгрөг нь төрөөс хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг, 1.9 тэрбум төгрөг нь “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд даатгуулагчдад үзүүлсэн элэгний В, С вирусийн ачаалал тоолох шинжилгээний гэрээт лабораториудад олгох, 0.2 тэрбум төгрөг нь бусад эрүүл мэндийн байгууллагад олгох санхүүжилтийн үлдэгдэл байна.

5.9. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 17,453.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 26,972.4 тэрбум төгрөг болж, 9,518.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,027,615.2	5,925,949.1	1,898,333.9	22.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	16,883,833.6	19,400,950.9	2,517,117.3	71.9
Хуримтлагдсан үр дүн	-5,342,622.7	-5,076,905.5	265,717.2	-18.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,869,444.8	6,737,722.7	4,868,277.9	25.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	16,109.2	-15,195.6	-31,304.8	-0.1
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-627.5	-134.3	493.2	0.0
Дүн	17,453,752.6	26,972,387.3	9,518,634.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу хуулийн этгээдүүд хөрөнгийн дахин үнэлгээ хийснээр Засгийн газрын хувь оролцоо данс өссөн байна. Тухайлбал: ЗТХС-ын харьяа байгууллагууд 3,064.8 тэрбум, БХС-ын харьяа байгууллагууд 643.7 тэрбум, СС-ын харьяа байгууллагууд 756.8 тэрбум, БСШУСС-ын харьяа байгууллагууд 1,177.8 тэрбум, УУХҮС-ын харьяа байгууллагууд хөрөнгийн дахин үнэлгээ, дэд бүтцийн зориулалттай газрыг бүртгэсэн 817.2 тэрбум, ЭМС-ын харьяа байгууллагууд 453.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Мөн УУХҮС-ын харьяа төрийн өмчит хувьцаат компанийн хувьцааны тоо нэмэгдэж 170.1 тэрбум, ЭМДЕГ Нийгмийн даатгалын сангийн балансаас хөрөнгө шилжүүлэн авсан 592.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

5.9.1. Төрийн өмчийн хувь оролцоо

ТЭЗ-дын Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 12,834.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 19,699.2 тэрбум төгрөг болж, 6,865.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 133 төрийн өмчит хуулийн этгээдээс 132 нь тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж, Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК татан буугдсан байна.

Тайлант онд 77 байгууллага буюу 58.3 хувь нь 950.6 тэрбум төгрөгийн ашигтай, 55 байгууллага буюу 41.7 хувь нь 173.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах төрийн өмчит байгууллагууд тайлант онд алдагдалтай ажилласан байна. Тухайлбал: ТОСК ХХК 18.9 тэрбум, ИНЕГ-ын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба 11.2 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК 7.0 тэрбум, Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК 6.4 тэрбум, Амгалан дулааны станц ТӨХК 6.3 тэрбум, Диспетчерийн үндэсний төв ХХК 5.9 тэрбум, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 5.0 тэрбум, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК 4.3 тэрбум, Шивээ овоо ТӨХК 2.3 тэрбум, Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 2.2 тэрбум, Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК 1.8 тэрбум, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК 1.5 тэрбум, Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар ТӨҮГ 1.5 тэрбум, Биокомбинат УТҮГ 1.4 тэрбум, Мон-Атом ХХК 1.3 тэрбум, Үндэсний дата төв УТҮГ 1.1 тэрбум, Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК 1.1 тэрбум төгрөг.

9.2. Орон нутгийн өмчийн хувь оролцоо

ТЕЗ-дын Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,619.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 7,273.1 тэрбум төгрөг болж, 2,653.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн өмчит 413 хуулийн этгээдээс 407 байгууллага 2018 онд үйл ажиллагаа явуулж, 6 байгууллага татан буугдсан байна. Үүнээс 164 байгууллага буюу 40.3 хувь нь 6.2 тэрбум төгрөгийн ашигтай, 243 байгууллага буюу 59.7 хувь нь 77.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах орон нутгийн өмчит байгууллагууд тайлант онд алдагдалтай ажилласан байна. Тухайлбал: Нийслэлийн Ус сувгийн удирдах газар 17.0 тэрбум, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 7.2 тэрбум, Зөрчигч тээврийн нэгтгэл 6.5 тэрбум, Геодези, усны барилга байгууламжийн газар 1.7 тэрбум, Чандмань налайх 1.1 тэрбум, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 0.8 тэрбум, Дархан-Уул аймгийн Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨҮГ 13.2 тэрбум, Сүхбаатар аймгийн Дарьганга тохижилт ОНӨҮГ 2.3 тэрбум, Дөрвөлж ОНӨҮГ 0.8 тэрбум, Ус-дулаан /Түмэнцогт/ ОНӨҮГ 0.5 тэрбум, Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар 1.5 тэрбум, Өмнөговь аймгийн Шугшаа уул ОНӨҮГ 1.5 тэрбум, Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ энерго ОНӨҮГ 1.3 тэрбум, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨҮГ 0.8 тэрбум, Говьсүмбэр аймгийн Илчлэг шивээ ОНӨҮГ 0.8 тэрбум, Увс аймгийн Дулааны станц 0.6 тэрбум төгрөг.

6. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

6.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж Зөрчилгүй 26, Хязгаарлалттай 4 дүгнэлт /БСШУСС, ХХААХҮС, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан/ өгч, 3 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд итгэл үзүүлээ.

Аудитаар нийт 2,350.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,233.0 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 6.1 тэрбум төгрөгийн зөрчилд 355 төлбөрийн акт тогтоож, 427.2 тэрбум төгрөгийн зөрчилд 638 албан шаардлага, 32 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 6 асуудлыг шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 684.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 1804 зөвлөмж өгсөн.

Тайлант онд улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагчдын харьяа ТТЗ 18, ТШЗ 345, ТӨҮГ 111, төсөл хөтөлбөр 91, Засгийн газрын тусгай сан 23, нийт 588 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж, 354 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн. Үүнээс Зөрчилгүй 291, Хязгаарлалттай 59, Сөрөг 3, Татгалзсан 1.

6.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Зөрчилгүй 19, Хязгаарлалттай 3 /Сэлэнгэ аймаг, Ховд аймаг, Нийслэл/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 579.3 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 335.2 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 6.4 тэрбум төгрөгийн зөрчилд 1048 төлбөрийн акт тогтоож, 79.7 тэрбум төгрөгийн зөрчилд 1676 албан шаардлага, 12.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил гаргасан 324 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 0.3 тэрбум төгрөгийн 7 асуудлыг шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 145.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 3645 зөвлөмж өглөө.

6.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Аудитаар нийт 499.6 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 374.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.5 тэрбум төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 37.1 тэрбум төгрөгийн зөрчилд 67 албан шаардлага хүргүүлж, 87.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 282 зөвлөмж өгч, 1 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Нийт 130 төрийн өмчит хуулийн этгээдээс 101 байгууллага аудитад хамрагдаж, Зөрчилгүй 84, Хязгаарлалттай 15, Сөрөг 2 дүгнэлт өгсөн байна.

үснэгт № 32. "Хязгаарлалттай", "Сөрөг" дүгнэлт өгсөн байгууллагууд

Хязгаарлалттай дүгнэлт:

1. Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ	10. Хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ
2. Хөвсгөл дулааны станц ТӨХК	11. Геологийн судалгааны төв ТӨААТҮГ
3. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК	12. Эрдэнэс Тавантолгой ХК
4. Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК	13. Монголын Төмөр зам ТӨХК
5. Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ	14. Дорноговь АЗЗА ТӨХК
6. Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК	15. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	Сөрөг дүгнэлт:
8. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	1. Бөртэ ТӨААТҮГ
9. Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ	2. Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ

Төрийн өмчит 13 байгууллагад Орон нутаг дахь төрийн аудитын байгууллага аудит хийж, 4 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, 12 байгууллага ТУЗ-ийн шийдвэрээр аудит хийлгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн өмчит 55 хуулийн этгээд 173.5 тэрбум, орон нутгийн өмчит 243 хуулийн этгээд 77.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 126.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Монголын Төмөр зам ТӨХК Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төслийн 57.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эзэмшигч тогтоох асуудал шийдэгдээгүй;
- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 1.0 тэрбум төгрөгийн норм, нормативын орлого, зардлыг санхүүгийн тайланд тусгаагүй, Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК 0.5 тэрбум төгрөгийн зардлыг ангилал буруу бүртгэсэн;
- Хөвсгөл дулааны станц ТӨХК орон нутгийн төсвийн 32 байгууллагад хүчингүй болсон тарифаар дулаан нийлүүлэх гэрээ хийснээр 0.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан;
- Тендерийн хууль зөрчиж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан /Бөртэ ТӨААТҮГ 1.9 тэрбум, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК 1.9 тэрбум төгрөг, Шивээ овоо ТӨХК 8.3 тэрбум, Геологийн судалгааны төв ТӨААТҮГ 1.0 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 2.9 тэрбум, МИАТ ТӨХК 1.3 тэрбум төгрөг/;
- Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламж даатгалын корпораци, Эрдэнэс алт ресурс ХХК, Эрдэнэс метан ХХК, Эрдэнэс ассет менежмент ХХК, Эрдэнэс Оюу Толгой ХХК Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна.

6.4. Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Монгол Улсын Засгийн газартай байгуулсан гэрээ хэлцлийн хүрээнд хөгжлийн түнш олон улсын 2 банк, санхүүгийн байгууллага болон 12 орны гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр Сангийн ямаар дамжин хэрэгжих 132 төсөл арга хэмжээг 945.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт № 33. Төслийн санхүүжилтийн эх үүсвэр

Төслийн санхүүжилтийн хэлбэр	Төслийн тоо	Нийт гэрээний дүн /сая нэгж/								Нийт /тэрбум төгрөг/
		Төгрөг	Доллар	Евро	Иен	Вон	Динар	Зээлжих тусгай эрх	Юань	
Зээлийн хөрөнгөөр	93	-	3,920.3	202.6	56,588.2	65,020.0	6.0	371.1	-	835.9
Буцалтгүй тусламжаар	39	8,996.2	112.3	15.1	10,400.0	990.1	-	-	2,542.9	110.0
Нэгжийн дүн	132	8,996.2	4,032.6	217.7	66,988.2	66,010.1	6.0	371.1	2,542.9	945.9

Эх сурвалж: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газар.

Нийт тайлант онд зээлийн 70, буцалтгүй тусламжийн 36 нийт 106 төсөл, хөтөлбөрт төсвөөс 77.5 хувь буюу 691.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан бөгөөд 26 төсөлд санхүүжилт олгогдоогүй байна. Санхүүжилтийн 72.8 хувь буюу 503.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад, 12.8 хувь буюу 88.8 тэрбум төгрөгийг урсгал үйл ажиллагаанд, 14.4 хувь буюу 99.1 тэрбум төгрөгийг цэвэр зээлд зарцуулжээ.

Тайлант онд нийт 156 /Сангийн ямаар дамжин хэрэгжих 132, ТЕЗ-д хамаарах 24/ төсөл хөтөлбөрөөс Үндэсний аудитын газар 1, хараат бус аудитын хуулийн этгээд 50, аудитын



гүврээр 40, нийт 91 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийснээс “Зөрчилгүй” 33, (язгаарлалттай” 18 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 308.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 27.0 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.04 тэрбум төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 40.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 24 албан шаардлага, 1 хариуцлага тооцох санал өгч, 240.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 89 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчил 0.1 тэрбум төгрөг; /Тухайлбал: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл 0.04 тэрбум, Глобал сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөл 0.04 тэрбум төгрөг/;
- Авлага, өр төлбөр нэмэгдсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 10.8 тэрбум төгрөг; /Тухайлбал: ТЭДС-КР-2 төслийн 7.4 тэрбум, ТЭДС-КР-1 төслийн 3.1 тэрбум төгрөг/;
- Төсөл хөтөлбөрийн 8 нэгж батлагдсан төсвийг 7.8 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Хөрөнгө оруулалтын зардлыг буруу бүртгэсэн /Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төслийн 38.5 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 69.8 тэрбум төгрөг/;
- Хөрөнгө тухайн байгууллагын эзэмшилд байхгүй /Бага оврын трактор худалдаж авах төслийн 12 трактор 57.6 сая төгрөг, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн Тоёота Ландкрузер-105 маркийн 36.1 сая төгрөгийн автомашин/;
- Нийт төсөл, хөтөлбөрөөс 65 нь Үндэсний аудитын газарт санхүүгийн тайлангаа ирүүлээгүй;

6.5. Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа Засгийн газрын 13 тусгай санд Төрийн аудитын байгууллага, 4 тусгай санд хараат бус аудитын хуулийн этгээд, 6 тусгай сан аудитын түүвэрт хамрагдсанаас Зөрчилгүй 10, Хязгаарлалттай 5 /Боловсролын зээлийн сан; Шинжлэх ухаан, технологийн сан; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан; Соёл, урлагийг дэмжих сан; Спортыг дэмжих сан/, Сөрөг 1 /Мал хамгаалах сан/, Дүгнэлт өгөхөөс татгалзах 1 /Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 578.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 333.1 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 185.0 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага хүргүүлж, 59.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 109 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын дүнг зөрүүтэй тайлагнасан, эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулаагүй 178.1 тэрбум төгрөг /Боловсролын зээлийн сан 145.8 тэрбум, Шинжлэх ухаан технологийн сан 0.3 тэрбум, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 0.1 тэрбум, Мал хамгаалах сан 1.5 тэрбум, ЖДҮХС 3.8 тэрбум, ТЭДС 19.9 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сан 6.7 тэрбум/;
- Боловсролын зээлийн сангийн зээлээр гадаадад суралцагч 263 иргэн 38.6 тэрбум төгрөгийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, сургалтын болон амьжиргааны зардлыг хувь хүний дансанд шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу 5.4 тэрбум төгрөг;
- Тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл, хөтөлбөрийг шалгаруулж, санхүүжилтийг олгосон, төслийн санхүүжилт, явц, үр дүнд бүртгэлээр тавих хяналт сул, төслүүдийн мэдээллийн сан санхүүгийн програмтай уялдаагүй 9.6 тэрбум төгрөг /Шинжлэх ухаан технологийн сан 7.3 тэрбум, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2.3 тэрбум төгрөг/;
- Зардлыг зориулалт бусаар зарцуулсан, хөрөнгийн ашиглалт хамгаалалт муугаас хөрөнгө ашиглах боломжгүй болсон, үргүй зардал гаргасан 1.2 тэрбум төгрөг /Соёл урлагийг дэмжих сан 0.01 тэрбум, Эрүүл мэндийг дэмжих сан 0.3 тэрбум, Мал хамгаалах сан 0.9 тэрбум/;
- Мал хамгаалах сангаас олгож байгаа зээлийг төлж барагдуулаагүй, барагдуулах талаар холбогдох арга хэмжээ аваагүй 5.0 тэрбум төгрөгийн алдаа зөрчлүүд илэрсэн.

7. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН ЗАЛРУУЛГА

Аудитаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайланд Төв төрийн сангийн 18.2 тэрбум төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл, үр дүнгийн тайланд 1.0 тэрбум, мөнгөн гүйлгээний тайланд 53.1 тэрбум төгрөгийн орлого, зардлын гүйлгээний давхардлыг залруулав.



ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Ерөнхий сайдад 4, Сангийн сайдад 4, ТӨБЗГ-т 2 зөвлөмж нийт 10 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 71.0 хувийн биелэлттэй байна.

Ерөнхий сайдад 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмж хэрэгжих шатандаа, Байгалийн баялгийн нөөцийг тогтоож, үнэлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн эзэмшлийн хөрөнгийн дүнг үнэн зөв бүртгэж, тайлагнах зөвлөмж хэрэгжээгүй, Сангийн сайдад 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж нь хэрэгжих шатандаа, ТӨБЗГ-т өгсөн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

9. ДОТООД АУДИТ

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, чанарын баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, нийслэл болон улсын ТЕЗ-дын дэргэдэх дотоод аудитын алба тайлант онд 1017 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж нийт 365.7 тэрбум төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснээс 41.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 324.4 тэрбум төгрөгийн албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитаар дээрх алдаа зөрчил илэрсэн нь төсвийн захирагчдын дотоод хяналт үр нөлөөгүй, нягтлан бодогч нарын мэдлэг, ур чадвар дутмаг, хариуцлага сул, тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаатай холбоотой байна.

ТЕЗ-дын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар улсын 8, орон нутгийн 12 ТЕЗ-ийн дотоод аудитыг үр нөлөөгүй гэж дүгнэсэн байна.

10. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитыг Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.10-д заасны дагуу гүйцэтгэсэн.

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн нь Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1705, Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам"-ын 13.5-д заасны дагуу Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн болно. Үүнд:

1. Татан буугдсан Капитал банканд төсвийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 245.4 тэрбум, дамжуулан зээлийн 3.5 тэрбум, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн авлага 1.6 тэрбум төгрөг нийт 250.5 тэрбум төгрөг оршин байхгүй, эргэн төлөгдөх эсэх нь эрсдэлтэй;
2. Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, зээл ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй нийт 1,006.7 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
3. Засгийн газрын тусгай сангийн холбогдох журмын шалгуур хангаагүй, төсөл арга хэмжээг санхүүжүүлж зээл олгосон, зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан;
4. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан бэлтгэх журмууд уялдаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, ашиглагдаж байгаа програм хангамж стандартад бүрэн нийцэхгүй байна;
5. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.



1. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас өмнөх оны алдаа зөрчил дахин давтагдаж, төсвийн захирагчдын санхүүгийн хариуцлага боломжит түвшинд хүрэхгүй байна.

Тухайлбал: 2017 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Ерөнхий сайдад өгсөн 4 зөвлөмжөөс гурав нь хангалтгүй, нэг нь огт хэрэгжээгүй, Сангийн сайдад өгсөн 4 зөвлөмжөөс 2 зөвлөмж хэрэгжсэн, 2 зөвлөмж хэрэгжих шатандаа, ТӨБЗГ-т өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй.

Төрийн аудитын байгууллагаас аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар шаардлагатай зарим Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнг УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга батыг сайжруулах тодорхой шийдвэр гаргуулах саналыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД:

- Татан буугдсан Капитал банканд байршиж байгаа харилцах, хадгаламжийн дансны болон дамжуулан зээлийн үлдэгдлийг барагдуулж, улсыг хохиролгүй болгох арга хэмжээ авах;
- Засгийн газрын тусгай сангаас олгох зээлийн шалгуурыг боловсронгуй болгох, төсөл сонгон шалгаруулах, зээл олгох, эргэн төлүүлэх үйл ажиллагааг цахимжуулах, олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах, найдваргүй зээлийг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдаагүй газар, үл хөдлөх хөрөнгийн судалгааг нарийвчлан гаргаж, үнэлгээ хийж бүртгэлд бүрэн тусгах;
- Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх заалтыг төсвийн ерөнхийлөн захирагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах, биелэлтийг хангуулж, хариуцлага тооцох;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн бүтэц, өмчийн эзэмшлийн хэлбэрийг тодорхой болгох, алдагдалтай ажилласан аж ахуйн нэгжүүдийн зардлыг хэмнэх, алдагдлыг бууруулах арга хэмжээ авах, үр дүнг тооцох;
- Авлага барагдуулах нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, үе шаттайгаар бууруулан хэрэгжилтийг үнэлэх.

САНГИЙН САЙДАД:

- Төрийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг боловсронгуй болгох, олон улсын чиг хандлагыг нэвтрүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагын санхүүгийн тайланг бүрэн нэгтгэх;
- Зээл ашиглагч байгууллагын хөрөнгө оруулалтад тооцох тухай Засгийн газрын холбогдох тогтоолтой 23.9 тэрбум төгрөгийн авлагыг данс бүртгэлээс хасах;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд 1991-1996 онуудад дамжуулан зээлийн гэрээгүй олгосон 293.6 тэрбум, Анод банканд олгосон 2.7 тэрбум төгрөгийн найдваргүй болсон дамжуулан зээлийн авлагыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх;
- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 297.7 тэрбум төгрөгийн зээлийн өглөгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын санхүүгийн тайланд бүртгэх;
- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ыг Өрийн удирдлагын тухай хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй нийцүүлэн шинэчлэн, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;



- Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, үйл ажиллагаа нь дууссан төсөл хөтөлбөрийн хөрөнгийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж байх;
- Санхүүгийн тайлан бэлтгэх журам, програм хангамжийг стандартад нийцүүлэн уялдуулж шинэчлэн боловсруулах, мөрдөж ажиллах;
- Төсвийн захирагчдын дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах, нягтлан бодогч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГАД:

- Төсвийн захирагчдын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой журмыг шинэчлэн сайжруулж, тус газраас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлага тооцох
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Монгол Улсын Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан"-г хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад тус тус зөвлөсүгэй.

3.Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ